

ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ОНЦГОЙ ЭРХИЙН ГЭРЭЭ

2017 оны дугаар
сарын-ны өдөр

№

Улаанбаатар
хот

Нэг талаас: Монгол улсын иргэн-ны /РД:/,
/цаашид “Худалдагч” гэх/,

нөгөө талаас: Монгол улсын иргэн-ны /РД:/ /цаашид
“Худалдан авагч”, хамтад нь “Талууд” гэх/ нар Монгол Улсын “Иргэний хууль”-ийн
холбогдох зүйл заалтуудыг үндэслэн дараах нөхцөлийг харилцан тохиролцож, энэхүү
“Худалдах, худалдан авах онцгой эрхийн гэрээ” /цаашид “Гэрээ” гэх/-г байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Энэхүү гэрээгээр Худалдан авагч нь гэрээнд заасан үнийг төлж, багаж хэрэгслийг худалдан авах, Худалдагч нь биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй, зориулалтын дагуу ашиглах бүрэн боломж бүхий багаж хэрэгслийг Худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэхтэй холбогдон талуудын хооронд үүсэх эрх зүйн харилцааг зохицуулна.
- 1.2 Гэрээний дагуу худалдаж буй багаж хэрэгслийн нэр, төрөл, загвар, тоо хэмжээ, зориулалт, үнэ зэргийг талууд гэрээний Хавсралт №1-ээр харилцан баталсан болно.
- 1.3 Талууд багаж хэрэгслийг хүлээлцэхдээ гэрээний Хавсралт №2-т заасан акт баримтыг үйлдэн, гарын үсгээр баталгаажуулан энэхүү гэрээнд хавсаргана.
- 1.4

Хоёр. Онцгой эрхийн тухай талуудын баталгаа, мэдэгдэл

- 2.1 Худалдагч нь Холбооны Бүгд Найрамдах Герман улсын “.....” компанийн үйлдвэрлэсэн зориулалт бүхий, загвартай, хүчин чадалтай багаж хэрэгслийг Монгол улсад худалдан борлуулах онцгой эрхтэй болохоо үүгээр баталж, энэхүү эрхийг гэрчлэх баримтыг гэрээнд хавсаргасан болно.
- 2.2 Худалдагч нь гэрээний 2.1-т заасан баталгааны дагуу энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлэх эрх зүйн чадамжтай бөгөөд гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй буюу Үйлдвэрлэгчээс олгосон онцгой эрх хүчингүй болсны улмаас Худалдан авагч болон бусад гуравдагч этгээдэд учирсан аливаа хохирлыг бүрэн барагдуулах санхүүгийн чадвартай болно.
- 2.3

Гурав. Гэрээний хугацаа

- 3.1 Энэхүү гэрээ нь оны ... дугаар сарын...-ний өдөр талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж, талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлснээр дуусгавар болно.
- 3.2 Талууд гэрээний хугацаанд өөрчлөлт оруулах тохиолдолд үүссэн нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгч харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээний хугацааг сунгаж болно.
- 3.3 Энэхүү гэрээ нь Худалдагчаас гаргаж буй техникийн баталгаат хугацаа дуусах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Дөрөв. Гэрээний үнэ, төлбөрийн нөхцөл

- 4.1 Гэрээний дагуу худалдан борлуулж буй багаж хэрэгсэл нэг бүрийн үнэ нь
/...../ төгрөг байхаар талууд харилцан тохиролцсон ба энэхүү үнийн дүнд уг багаж хэрэгслийг савалж баглах, Худалдан авагчид тээвэрлэн хүргэх зардал багтсан болно.
- 4.2

Тав. Багаж хэрэгсэл худалдан авах захиалга өгөх, захиалга хүргүүлэх, хүлээн авах

- 5.1 Худалдан авагч нь багаж хэрэгсэл худалдан авах саналаа хуанлийн ... хоногийн өмнө Худалдагчид бичгээр /цахим шуудан, факс/ мэдэгдэх ба Худалдагч нь уг мэдэгдлийг хүлээн авсан даруй Үйлдвэрлэгч компанид багаж хэрэгсэл бэлтгэн нийлүүлэх захиалга өгнө.
- 5.2 Худалдагчаас багаж хэрэгслийг захиалгын дагуу нийлүүлэхэд бэлэн болсон тухай хариу мэдэгдэл ирсэнээс хойш Худалдан авагч нь хуанлийн ... хоногийн дотор бүтээгдэхүүний үнийг гэрээний 4.2-т заасан дансанд шилжүүлнэ.
- 5.3

Зургаа. Техникийн баталгаа

- 6.1 Худалдагч нь багаж хэрэгслийг Худалдан авагчид хүлээлгэн өгсөн өдрөөс хойш 2 жилийн хугацаанд техникийн баталгаа гаргаж буй болно.
- 6.2

Долоо. Багаж хэрэгслийн шинэчлэл, өөрчлөлтийн талаар мэдээлэх

- 7.1 Худалдагч нь багаж хэрэгслийн зориулалт, хэрэглээний шинж чанар, ажиллуулах зааварчилгаа, техникийн горим, системийн онцлог, хадгалах, хэрэглэх, тээвэрлэх нөхцөл, эдэлгээний хугацаа болон Үйлдвэрлэгчтэй холбогдсон үнэн зөв мэдээлэл өгөх үүрэгтэй.
- 7.2

Үргэлжлэл бий /7х/